



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.“Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001755

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн
13... дугаар тогтоолын хавсралт

**"Архангай-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашин**

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Краз-256 маркийн, АРА 11-88 улсын дугаартай, Арлын дугаар -612188, Хөдөлгүүрийн дугаар -095192	1988/1988	259920	1,085,400.00	1,085,400.00	0.00		500,000.00
				1,085,400.00	1,085,400.00	0.00	0.00	500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун)	1,085,400.00 (нэг сая наян таван мянга дөрвөн зуун)			500,000.00 (таван зуун мянга)